



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2024 оны 12 дугаар сар

АУДИТЫН СЭДЭВ: ОРХОН АЙМГИЙН 2025
ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Ерөнхий мэдээлэл	5
НЭГ. ОРХОН АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ БОЛОН ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	6
Орхон аймгийн 2025 оны төсвийн төсөл нь тогтвортой хөгжлийн бодлого, 2025 оны хөгжлийн төлөвлөгөөтэй нийцсэн байна	6
Аймгийн 2025 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна.....	9
ХОЁР. АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 135.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЖ, ЗАРДЛЫГ 2,163.9 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА.....	11
Төсвийн орлогыг 135.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.....	11
Төсвийн зарлагыг 2,163.9 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.....	13
Төсвийн төслөд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний эдийн засгийн үр ашгийн тооцооллыг хийхгүй төлөвлөсөөр байна.	15
ДҮГНЭЛТ:.....	15
ЗӨВЛӨМЖ:.....	17



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
БХС	Байгаль хамгаалах сан
АЗС	Автозамын сан
ЭС	Эрдэнэт сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ХББЗА	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдэв”-ийн дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн Орхон аймгийн 2025 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, орон нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, холбогдох шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхэд дүгнэлт гаргахад аудитын зорилт оршино.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төсвийн төсөл нь тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн, Төсвийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх;
- Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсөв, Орхон аймгийн 2023, 2024 оны батлагдсан төсөв /тодотгосон/, төсвийн гүйцэтгэл /батлагдсан болон урьдчилсан/, 2025 оны төсвийн төсөл, танилцуулга, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллагуудаас ирүүлсэн судалгаа болон холбогдох бусад баримт материалд үндэслэн гүйцэтгэв.

Аудитад Орхон аймгийн Засаг даргын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд цуглуулсан төсөвт байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт зэргийг ашиглав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж, ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлалд заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Болормаа, В.Жавзмаа, Г.Оргилмөрөн, Б.Азжаргал, Ц.Даваасүрэн, О.Гантуяа, Ж.Наранчимэг, Ц.Одгэрэл нар 2024 оны 12 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.



**Аудитын явцад
учирсан хүндрэл,
бэрхшээлүүд:**

Эцэслэн боловсруулсан төсвийн төслийг хүлээн авснаас хойш 5 хоногт гүйцэтгэсэн болон аудитад ирүүлсэн төсвийн төсөл иж бүрэн бус байсан зэрэг нь аудитын цар хүрээг хязгаарлах нөхцөл болсон.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны төсөвт бүхэлд нь хориг тавьснаар Засгийн газраас дахин боловсруулан, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаар баталсан.

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хурал баталсан нь шинэ 30 жилийн хөгжлийн гараа, нийгэм эдийн засгийн реформын эхлэл гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоол батлагдсан.

Улмаар Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Бүсчилсэн хөгжлийн татварын бодлогыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 111 дүгээр тогтоол батлагдаж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох татварын хувь хэмжээг бүсийн тэргүүлэх чиглэл, нийгэм, эдийн засгийн онцлогт нийцүүлэн тогтоож, 2025 оны төсвийн жилээс мөрдөхөөр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна.

Энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилт тавьсан байна.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хот хөдөөгийн сэргэлт, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд Үндэсний орон сууцны корпорацыг байгуулж иргэдийг орон сууцжуулах цогц бодлогуудыг хэрэгжүүлэх шаардлагатайг дурдсан байна.

Засгийн газраас эрчим хүчний салбарын шинэчлэлийг хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор орон нутгийн өмчийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг Эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ирүүлсэн тооцооллын дагуу орон нутгийн суурь зардалд тусгасан. Төсвийн төслийг боловсруулахдаа гэрэл, цахилгаан, түлш, халаалтын зардлыг холбогдох байгууллагаас тогтоосон үнэ тариф, тогтоолын дагуу тооцож тусгах чиглэл ирсэн байна. Орон нутгийн төсөвт байгууллага, төрийн өмчийн 30 цэцэрлэг, 18 сургууль, соёлын 10 байгууллага, Биеийн тамир спортын газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа орон нутгийн өмчийн барилгын ашиглалтын зардал, урсгал засварын зардал төлөвлөгдсөн байна.



Мөн орон нутгийн төсөвт байгууллагуудад ажиллах "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д "5 болон 7 хүний бүрэлдэхүүнтэй дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулал олгоно. 3 хүний бүрэлдэхүүнтэй дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний урамшууллыг улирал тутамд олгоно." гэж заасны дагуу урамшуулал олгох зардлыг цалингийн зардал, тэтгэмж урамшууллын зардлуудад тусгасан байна.

Аймгийн төсвөөс санхүүждэг байсан Хот тохижуулах газар, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрыг Баян-Өндөр сумын төсвийн орлогоос санхүүжүүлэх, Байгаль хамгаалах сангийн төсвийг аймгийн төсөвт шилжүүлэхээр 2025 оны төсвийн төсөлд тусгажээ.

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тооцож шаардлагатай зардлыг төсвийн төсөлд тусгажээ.

2025 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн 16 байгууллагын 808 албан хаагч, улсын төсвийн 85 байгууллагын 4383 албан хаагч нийт 101 төрийн байгууллагын 5191 албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгохоор нийт 21.7 тэрбум төгрөгийг төсөвт тусгаснаас 6.4 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллага, 15.3 тэрбум төгрөгийг улсын төсвийн байгууллагын албан хаагчдад олгохоор байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан тус хуулийн 52.7 дахь хэсгийн дагуу төсвийн шууд захирагч нарын төсөвт 96.5 сая төгрөгийг тусгасан бөгөөд уг зардал нь хүүхдэд ээлтэй, таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад зарцуулагдахаар хуульчлагдсан байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал батлах тухай" 445 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", Сангийн яамны Төсвийн Ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж, чиглэлийг үндэслэн аймгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулсан байна.



НЭГ. ОРХОН АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ БОЛОН ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.


1.1 Орхон аймгийн 2025 оны төсвийн төсөл нь тогтвортой хөгжлийн бодлого, 2025 оны хөгжлийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.

Орон нутгийн төсвийн орлого 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 350,559.70 сая төгрөг төвлөрүүлэхээс 319,352.4 сая төгрөг төвлөрч гүйцэтгэл 91.1 хувьтай байна.

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг 408,475.9 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Дүрслэл 1. Зардлын эзлэх хувь

/сая.төгрөг/



Аймгийн 2025 оны төсвийн 145,266.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг, 2,755.6 сая төгрөгийг дамжуулан зээлийн эргэн төлөлт, 45,049.4 сая төгрөгийг төрийн байгууллагын урсгал санхүүжилт, 184,065.8 сая төгрөгийг хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, 23,280.8 сая төгрөгийг сумдын ОНХС-д, 8,057.5 сая төгрөгийг орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээ ашиглалтын зардалд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй харуулбал.

Хүснэгт 1. Зардлын харьцаа ба хувь

/сая.төгрөг/

№	Зардлын ангилал	2024	2025	Өсөлт, бууралт	Хувь
1	Орон нутгийн төрийн байгууллагын санхүүжилт	40,111.6	36,592.7	-3,518.9	-9.6
2	Жаргалант суманд олгох санхүүгийн дэмжлэг	8,252.9	8,456.7	203.8	2.4
4	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	74,425.4	121,662.2	47,236.8	38.8
5	Аймгийн ОНХС	71,756.0	55,565.6	-16,190.4	-29.1
6	Авто замын сан	1,971.4	2,216.0	244.6	11.0
7	Байгаль хамгаалах төсөл арга хэмжээ	2,729.6	4,622.0	1,892.4	40.9
8	Баян-Өндөр сум ОНХС	11,290.7	12,238.7	948.0	7.7




9	Жаргалант сум ОНХС	10,358.2	11,042.1	683.9	6.2
10	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын ашиглалт зардал	7,694.1	8,057.5	363.4	4.5
11	Улсын төсөвт төвлөрүүлэх	137,661.3	145,266.8	7,605.5	5.2
12	Дамжуулан зээлийн эргэн төлөлт	2,956.8	2,755.6	-201.2	-7.3
ДҮН		369,208.0	408,475.9	39,267.9	9.6

Хүснэгтээс харахад нийт зардал 39,267.9 сая төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн байна. Тухайлбал: Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардал өмнөх оноос 47,236.8 сая төгрөгөөр буюу 38.8 хувиар, улсын төсөвт төвлөрүүлэх орлого 7,605.5 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар, байгаль хамгаалах арга хэмжээний зардал 1,892.4 сая төгрөгөөр буюу 40.9 хувиар өссөн, орон нутгийн төрийн байгууллагын санхүүжилт 3,518.9 сая төгрөгөөр буюу 9.6 хувиар, аймгийн ОНХС-ийн зарцуулалт 16,190.4 сая төгрөгөөр буюу 29.1 хувиар тус тус буурсан байна.

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын зардалд шилжих хөрөнгө оруулалтаар 56,183.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 57 ТАХ, шинэ хөрөнгө оруулалтад 88,068.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 136 ТАХ, төсөл хөтөлбөрийн 12,328.9 сая төгрөгийн 150 ТАХ, авто замын сангийн 2,216.0 сая төгрөгийн 5 ТАХ, Байгаль хамгаалах сангийн 4,622.0 сая төгрөгийн 33 ТАХ, Эрдэнэт сангийн 6,541.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ, Орон нутгийн хөгжлийн сангийн 77,077.8 сая төгрөгийн 63 ТАХ нийт 247,039.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 450 ТАХ-г 187,559.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

Дүрслэл 2. Хэрэгжүүлэх ТАХ-ний тоо, дүн

/сая, төгрөг/



Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төрөл

/сая, төгрөг/

№	Төсөл арга хэмжээний төрөл	ТАХ тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	
1	Шилжих хөрөнгө оруулалт	Барилга байгууламж	43	53,030.54	21,622.54
2		Их засвар	-	-	-
3		Зөвлөх үйлчилгээ	1	1,661.88	1,661.88
4		Тоног төхөөрөмж	13	1,491.06	1,079.79
5	Шинэ хөрөнгө оруулалт	Барилга байгууламж	19	22,375.43	19,275.42
6		Болзошгүй аваарын зардал	1	2,000.0	2,000.0
7		Зөвлөх үйлчилгээ	1	5,000.0	5,000.0
8		Их засвар	86	51,225.51	51,225.51
9		тоног төхөөрөмж	29	7,468.03	7,468.03
10	Төсөл хөтөлбөр	150	12,328.98	12,328.98	
11	Авто замын сан	Барилга байгууламж	3	1,581.87	1,581.87
12		тоног төхөөрөмж	1	604.13	604.13



13		Төсөл хөтөлбөр	1	30.0	30.0
14	Эрдэнэт сан	Төсөл хөтөлбөр	2	42.08	42.08
15		Шинэ хөрөнгө оруулалт	4	6,499.91	3,451.66
16	Байгаль хамгаалах сан	Шилжих үлдэгдэл	1	129.6	129.6
17		Барилга байгууламж	20	4,260.79	4,260.79
18		Төсөл хөтөлбөр	12	231.62	231.62
19	Орон нутгийн хөгжлийн сан	Шилжих үлдэгдэл	44	54,414.50	33,302.34
20		Барилга байгууламж	18	22,153.29	21,753.29
21		Төсөл хөтөлбөр	1	510.0	510.0
Нийт			450	247,039.22	187,559.53
Үүнээс:					
Зөвлөх үйлчилгээ, Болзошгүй аваарын зардал, Төсөл хөтөлбөр			169	21,804.56	21,804.56
Хөрөнгө оруулалт			281	225,234.66	165,754.97

Дээрх 247,039.2 сая төгрөгийн 450 ТАХ-ээс 21,804.6 сая төгрөгийн 169 ТАХ нь зөвлөх үйлчилгээ, болзошгүй аваарын зардал, урсгал үйл ажиллагааны шинж чанартай төсөл хөтөлбөрийн зардал бөгөөд энэ нь Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдаж байгаа эсэхийг үнэлж дүгнэх боломжгүй байна.

Харин төсвийн төсөлд тусгагдсан 148,666.9 сая төгрөгийн өртөг бүхий 219 ТАХ-г Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8 чиглэлээр 42 зорилттой тулган баталгаажуулалт хийхэд 96.8 хувь буюу 212 ТАХ нийцсэн байна. Үүнд:

Хүснэгт 3. 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан байдал

/сая.төгрөг/

№	Зорилт	ТАХ тоо	Эзлэх хувь	Төсөвт өртөг
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	-	-	-
2	Хүний хөгжил	161	73.52	98,591.98
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	10	4.56	33,750.72
4	Эдийн засаг	1	0.46	350.0
5	Сайн Засаглал	9	4.1	8,101.95
6	Ногоон хөгжил	16	7.3	1,757.69
7	Амар тайван аюулгүй байдал	10	4.56	4,518.62
8	Бүсчилсэн хөгжил	5	2.28	1,301.87
9	Тусгагдаагүй бусад	7	3.19	294.04
Нийт		219	100	148,666.87

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдаагүй 294.0 сая төгрөгийн өртөгтэй 7 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн нь 3.19%-ийг эзэлж байна. Тухайлбал:

- ГХБХБГ-т байгууллагын болон албаны нууцын хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 28.3 сая төгрөг,
- Далд шугам сүлжээ илрүүлэгч багаж /RD 8200/ худалдан авах 65.0 сая төгрөг,
- Төрийн архивд шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллах нөхцөлийг сайжруулах 30.4 сая төгрөг,
- Статистикийн хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах 19.5 сая төгрөг,



- Хүн ам, орон сууцны завсрын тооллого хийх үйл ажиллагаанд хэрэгцээт тоног төхөөрөмж худалдан авах 19.9 сая төгрөг,
- Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаанд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 33.9 сая төгрөг,
- Зэст баг. Шуудангийн үйлчилгээний газрын хэсэгчилсэн засвар хийх 97.0 сая төгрөг байна.

Орхон аймгийн ИТХ-ын 2024 оны 18/02 дугаар тогтоолоор Орхон аймгийн хөгжлийн 2025 төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн 160,995.85 сая төгрөгийн өртөг бүхий 369 төсөл арга хэмжээг нийцэж буй эсэхийг тулгахад:

Хүснэгт 4. Орхон аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөтэй уялдсан байдал /сая.төгрөг/

№	Зорилт	TAX тоо	Эзлэх хувь	Төсөвт өртөг
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	9	2.44	565.00
2	Эрүүл бүтээлч хөгжих тэмүүлэлтэй Эрдэнэт хүн	71	19.24	30,109.0
3	Амьдралын чанарын дундаж давхарга	27	7.32	31,433.87
4	Эдийн засаг	8	2.17	3,910.27
5	Тогтвортой засаглал	55	14.9	5,376.6
6	Ногоон Эрдэнэт	30	8.13	9,301.13
7	Аюулгүй амар тайван Эрдэнэт хот	26	7.05	1,443.87
8	Тогтвортой хөгжил	120	32.52	76,342.42
9	Тусгагдаагүй бусад	23	6.23	2,513.68
	Нийт	369	100	160,995.85

Орхон аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөтэй 87.81% буюу 146,503.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 324 төсөл арга хэмжээ нийцэж байгаа бол 12.19% буюу 14,492.8 сая төгрөгийн 45 төсөл арга хэмжээ нийцэхгүй байна. Тухайлбал:

- Илгээлтийн эздийн 50 жилийн ойн хүрээнд ахмадуудад олгох мөнгөн урамшууллын үлдэгдэл санхүүжилт 94.5 сая төгрөг
- Монгол Улсад хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх зардал 20.0 сая төгрөг
- Ахмадуудад сар шинийн хүндэтгэл үзүүлэх зардал 90.0 сая төгрөг
- Аймгийн хэмжээнд зохион байгуулагддаг тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах үйл ажиллагааны зардал 190.0 сая төгрөг
- Улсын аварга малчид, тариаланчдад хүндэтгэл үзүүлэх зардал 8.0 сая төгрөг
- Авто тээвэрчдийн улсын зөвлөгөөн зохион байгуулах зардал 20.0 сая төгрөг гэх мэт.

1.2 Аймгийн 2025 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2025 оны төсвийн төсөлд тусгагдсан TAX-г аймгийн ИТХ-ийн төлөөлөгчдийн болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын саналд үндэслэн ач холбогдлоор нь эрэмбэлсэн боловч Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг



төлөвлөх, хянах, тайлагнах журам”-ын 2.2¹, 2.2.2² дахь заасны дагуу эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийг хэрхэн тодорхойлсон талаар нотлох баримт хангалтгүй байна.

2025 оны төсвийн төсөлд тусгагдсан хөрөнгө оруулалтын шинж чанартай 225,234.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 165,754.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 281 төсөл арга хэмжээнээс зураг төсөв байх шаардлагатай 86,268.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 83,768.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 130 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

№	Төсөл арга хэмжээний нэр		TAX тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	ОНХО	Барилга байгууламж	19	22,375.4	19,275.4
2		Их засвар	73	39,547.5	39,547.5
3	Байгаль хамгаалах сан	Барилга байгууламж	19	4,210.8	4,210.8
4	Авто замын сан	Барилга байгууламж	3	1,581.9	1,581.9
5	ОНХС	Барилга байгууламж	16	19,553.3	19,153.3
Нийт			130	86,268.9	83,768.9

2025 оны төсвийн төсөлд шинээр гүйцэтгэхээр тусгагдсан 130 төсөл арга хэмжээнээс аудитын хугацаанд “Эрдэнэт ус” ОНӨХК, ЭБЦТС ТӨХК-иас ирүүлсэн цахилгааны болон УДДТ-тэй холбоотой 50,616.2 сая төгрөгийн төсөв, санхүүжих дүнтэй 77 TAX-ны зураг төсөв, ОНХС-ийн эх үүсвэрээс төлөвлөгдсөн 19,017.5 сая төгрөгийн 17 TAX нь авто зам, засварын ажлын зураг төсөв, 6,269.8 сая төгрөгийн өртөгтэй, 5,169.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 11 TAX-г ХББЗА ОНӨААТҮГ, ХЗА-ны жишиг зураг төсөвтэй тулган баталгаажууллаа. 25 TAX-ний зураг төсвийг аудитын хугацаанд ирүүлээгүй.

Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтын шилжих үлдэгдэл болон шинээр хийгдэх хөрөнгө оруулалтад эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, цаашид төсвөөс гарах урсгал зардлын тооцоо судалгаагүй төлөвлөгдсөн нь Төсвийн тухай хуулийн 29.4, 29¹.1, 29².4-т заасантай тус тус нийцэхгүй байна. Үүнд:

- Эрдэнэтэд үйлдвэрлэв барилга барих
- Сум дундын ойн ангид граж барих
- Спорт заалны барилга барих
- Хурдан морь барианы газар тохижилт
- Орхон аймгийн төвийн хэсэгт дугуйн зам хийх

ХОЁР. АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 135.0 СЯА ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЖ, ЗАРДЛЫГ 2,163.9 СЯА ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

2.1 Төсвийн орлогыг 135.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Сангийн яамнаас Орхон аймгийн 2025 оны суурь орлогыг 266,312.1 сая төгрөгөөр, суурь зарлагыг 76,367.3 сая төгрөгөөр хянаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол

¹ төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

² төсөл арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл арга, хэмжээнүүдийг тодорхойлох жагсаалт гаргах.



Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд Орхон аймгаас Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 145,266.8 сая төгрөгөөр тусгасан байна.


Төсвийн тухай хуулийн 8.3.4³-д заасан Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу Орхон аймгийн төсвийн төслийг боловсруулж хүргүүлсэн байна.

Удирдамжид Бүсчилсэн хөгжлийг дэмжих татварын бодлогын хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль, Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай багц хуулийн төслийг баталсан байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жил 90 хувиар хөнгөлөлт эдлүүлэх зохицуулалтыг тусгасан байна.

Орхон аймгийн 2025 оны төсвийн орлогыг нийт дүнгээрээ 408,475.9 сая төгрөгөөр төлөвлөсний 47.4 хувь буюу 193,539.2 сая төгрөгийн татварын болон татварын ус орлогоор, 38.5 хувь буюу 157,507.4 сая төгрөгийг тусламжийн орлогоор, 28.1 хувь буюу 114,779.8 сая төгрөгийн сумаас аймагт төвлөрүүлэх орлого, 14.1 хувь буюу 57,429.3 сая төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс тус тус бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Дүрслэл 4. Орлогын бүтэц /сая. төгрөг/



Дүрслэл 5. Орлогын эзлэх хувь



Орхон аймгийн 2025 оны төсвийн төсөлд Сангийн яамны хянасан татварын орлогыг 56,814.0 сая төгрөг, татварын бус орлогыг 2,898.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Төсөвт байгууллагын өөрийн орлогод цэвэрлэх байгууламжийн төслийн 2,419.0 орлогыг нэмж төлөвлөсөн байна.

Хүснэгт 6. Төсвийн орлогын төрөл

/сая төгрөг/

³Төсвийн тухай хуулийн 8.3.4-д “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”,



Орлогын төрөл	Татварын орлого	Татварын бус орлого	Тусламжийн орлого
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	180,000.0	-	-
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,500.0	-	-
Улсын тэмдэгтийн хураамж	1,000.0	-	-
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	800.0	-	-
Хүү, торгуулийн орлого	-	1,850.0	-
Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	2,457.1	-
Түрээсийн орлого	-	732.1	-
Орон нутгийн өмчийн эд хөрөнгө борлуулсны орлого	-	5,200.0	-
Хандив тусламжийн орлого	-	-	4,000.0
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	38,727.7
ДҮН	183,300.0	10,239.2	42,727.7

Орхон аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын нэмэлт дансанд 12 дугаар сарын байдлаар газрын эрхийн шимтгэлийн 133.6 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Дүрслэл 7. Орлогын бүтэц

/сая.төгрөг/



Энэ нь төлөвлөгдөөгүй орлого бөгөөд төсвийн орлогыг 2025 онд 135.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн төслөө Төсвийн тухай хуулийн 31.1.3⁴-д заасны дагуу тус хуулийн 4.1.8⁵-д заасан жилийн төсвийн хязгаарт багтаан төлөвлөх ёстой.

Баян-Өндөр сумын төсвийн орлогыг 149,997.1 сая төгрөгөөр хянаж, 114,779.7 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр, Жаргалант сумын төсвийн орлогыг 670.4 сая

⁴ Төсвийн тухай хуулийн 31.1.3-д "жилийн төсвийн хязгаарт багтаасан байх",

⁵ Төсвийн тухай хуулийн 4.1.8-д "жилийн төсвийн хязгаар" гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдээгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг",



төгрөгөөр хянаж, суманд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 8,456.6 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

2.2 Төсвийн зарлагыг 2,163.9 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.

Аймгийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад тусгасан шинээр эхлэх хөрөнгө оруулалтын барилга байгууламжид дэд станц барих төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан нь Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-н 3.1⁶-д заасан байгалийн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн үйлчилгээ иргэдэд хүртээмжтэй байх төрийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ТЕЗ, харьяа яам нь төсвийн байгууллагын бүтэц орон тоо, урсгал зардлыг баталдаг.

Хүснэгт 6. Төсөл хөтөлбөрт туссан гэрээт ажилчдын тоо, төсөв

/сая.төгрөг/

№	Байгууллагын нэрс	Ажилтны тоо	Төсөвт өртөг
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын угтах үйлчилгээний зардал	1	30.0
2	Түргэн тусламжийн үйл ажиллагааны зардал	9	385.0
3	Туслах сувилагч ажиллуулах зардал /12хүн/	12	78.0
4	Нийгмийн даатгалын төлөөлөгчдийн зардал	10	59.4
5	Ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааны зардал	9	261.9
6	Америк соёл мэдээллийн төвийн цалин, НДШ ийн зардал	3	103.4
7	Хувь хүний орлогын албан татварын хэсгийн урсгал зардал	8	176.2
8	Эрх зүйн хөтөч ухуулагчдын цалингийн зардал	8	78.5
9	Цагдаагийн газрын олон нийтийн цагдаагийн ажилтны цалин, НДШ-ийн зардал	39	390.0
10	Мэдээлэл лавлагаа хариуцсан туслах ажилтан болон төрийн архивын гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардал	5	92.6
11	Иргэний бүртгэлийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн архивыг цахимжуулах гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардал	4	54.0
12	Эрдэнэт спорт амралтын хүрээлэнгийн үйл ажиллагааны зардал /харуул, гэрэл цахилгаан/	6	134.9
13	Орон нутгийн циркийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардал	2	30.0
14	Хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байрны үйл ажиллагаа, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын зардал	2	40.0
Нийт		118	1,913.9

Орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлаас жил бүр 1,913.9 сая төгрөгийн 118 гэрээт ажилтныг байнгын орон тоонд ажиллуулж, чиг үүргийн давхардлыг үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлсээр байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл “Хэмнэлтийн бусад арга хэмжээ”-ний 15.1.2⁷-той нийцэхгүй байна.

⁶ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.

⁷ “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”



Аймгийн баяр наадмын зардлын задаргаанд тооцоолол хийгдээгүй байна.

Дүрслэл 8. Аймгийн баяр наадмын зардал

/сая,төгрөг/



Орхон аймгийн баяр наадмын зардлын 510.0 сая төгрөгийн 100.0 сая төгрөг нь Эрдэнэт үйлдвэрийн хамтын ажиллагааны орлогоос, 10.0 сая төгрөг нь үйл ажиллагааны орлогоос, 400.0 сая төгрөгийн ОНХС-аас санхүүжүүлэхээр тусгажээ. Баяр наадмын зардлыг Сангийн яам 150.0 сая төгрөгөөр хянасан. Иймд ОНХС-аас санхүүжүүлэхээр тусгасан 400.0 сая төгрөгөөс 250.0 сая төгрөгийг хэмнэх нь зүйтэй байна.

Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний эдийн засгийн үр ашгийн тооцооллыг хийхгүй төлөвлөсөөр байна.

Орхон аймгийн 2025 оны төсвийн төсөлд нийт 247,039.1 сая төгрөгийн өртөгтэй 450 төсөл арга хэмжээг 187,559.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 7. Төсөл арга хэмжээний ерөнхий мэдээлэл

/сая.төгрөг/

№	ТАХ төрөл	Шилжих ТАХ			Шинэ ТАХ			Нийт ТАХ		
		тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Барилга байгууламж	44	53,160.1	21,752.1	60	50,371.4	46,871.37	104	103,531.5	68,623.5
2	Их засвар	44	54,414.50	33,302.30	90	57,725.4	54,677.17	134	112,139.9	87,979.5
3	Тоног төхөөрөмж	13	1,491.1	1,079.8	30	8,072.2	8,072.16	43	9,563.3	9,152.0
4	Зөвлөх үйлчилгээ	1	1,661.9	1,661.9	1	5,000.0	5,000.00	2	6,661.9	6,661.9
5	Төсөл арга хэмжээ	-	-	-	166	13,142.7	13,142.70	166.00	13,142.7	13,142.7
6	Болзошгүй аваар	-	-	-	1	2,000.0	2,000.00	1.00	2,000.0	2,000.0
Нийт		102	110,727.6	57,796.1	348.0	136,311.7	129,763.40	450.0	247,039.22	187,559.53

Барилга байгууламжийн 104 төсөл арга хэмжээ, их засварын 134 төсөл арга хэмжээ нийт 238 төсөл арга хэмжээ нь нийт хөрөнгө оруулалтын ажлын 52.8%-ийг эзэлж байгаа бол төсөл хөтөлбөр, зөвлөх үйлчилгээ, болзошгүй аваарын зардлууд 47.2%-ийг эзэлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15.2-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэж заасан байтал өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чиг үүрэгтэй байгууллагад 1,198.3 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашигт байдлыг алдагдуулжээ. Тухайлбал:

- “Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨҮГ-д шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 33.9 сая төгрөг,
- "Орхон АЗЗА ТӨХК"-т техник худалдан авах 350.0 сая төгрөг,



- "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-ын НДШ, 2025 оны цалин НДШ-ийн зардал 157.6 сая төгрөг,
- "Аялал жуулчлал, амралтын их шүтээн цогцолбор" ОНӨҮГ-ын үйл ажиллагааны зардал 112.7 сая төгрөг,
- "Эрдэнэт" цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны үйл ажиллагааны зардал 544.1 сая төгрөг байна.

Мөн төсөл хөтөлбөрийн зардалд төлөвлөсөн 150 төсөл арга хэмжээг Орхон аймгийн иргэдэд ач тусаа хэрхэн өгснийг үнэлж дүгнээгүй, үр ашгийг тооцоогүй жил бүр төсөвт төлөвлөсөөр байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төсвийн төсөл нь тогтвортой хөгжлийн бодлого, аймгийн хөгжлийн хөтөлбөртэй нийцсэн байна.
- Төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна.
- Төсвийн орлогыг 135.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
- Төсвийн зарлагыг 2,163.9 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.
- Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний эдийн засгийн үр ашгийн тооцооллыг хийхгүй төлөвлөсөөр байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг даргад:

- Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгахгүй байх
- Төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг үнэлж эрэмбэлэн, үргэлжлэх хугацааг үндэслэлтэй төлөвлөх.